



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 4/31

Улаанбаатар хот

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах нөөц бүрдүүлэх тухай

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.2.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.3, 34.1.5 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.6 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 03/03 дугаар зөвлөмж, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/93 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах, эм, эмнэлгийн хэрэгсэл, цус цусан бүтээгдэхүүний нөөц хангамжийг тогтвортой байлгах зорилгоор гамшгийн үед ашиглах урвалж, оношлуур, хүүдийний нөөц бүрдүүлэн ажиллахыг холбогдох алба, тасгийн дарга, эрхлэгч нарт даалгасугай.

2. Өндөржүүлсэн бэлэн байдалтай холбогдуулан цус, цусан бүтээгдэхүүний нөөц хангамжийг тогтвортой байлгахад шаардлагатай урвалж, оношлуур, хүүдийний нөөцийг тус төвийн 2020 оны тендерт ялсан компаниудтай нэмэлт гэрээ байгуулан, тээвэрлэлт, хадгалалтын онцгой нөхцөлийг харгалзан яаралтай бүрдүүлэхийг Стратеги төлөвлөлт, санхүү бүртгэлийн албаны дарга /Ч.Батболд/, Ахлах нягтлан бодогч /Б.Өнөрзул/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Болзошгүй гамшиг, осол, хордлого, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах төлөвлөгөөг мөрдөн, эмнэлгийн яаралтай тусламж, нөөц

C:\Users\User\Documents\Received Files\Бэлэн байдлын нөөц бүрдүүлэх [1].docx

080293

хангамж, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн мэргэжлийн ангийн нарийн бичгийн дарга /Ч.Далайцэрэн/, Хүний халдварт өвчний дэгдэлтийн үеийн Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн Эрүүл мэндийн сайдын тушаалын хэрэгжилтийг хангаж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Чанар, цусны сонор сэрэмжийн албаны дарга /Т.Алимаа/ нарт тус тус даалгасугай.

4. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, нөөц бүрдүүлэхэд шаардлагатай урвалж, оношлуур, хүүдийний зардлыг эм, эмнэлгийн хэрэгслийн зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Өнөрзул/-д зөвшөөрсүгэй.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР